



НЬЮ ЖУУЛЧИН ТУРС
ДЭЭХИГЭЭР АВАХ ТАМУ МӨРӨӨДӨРГТ БИЭ ШИЛЭГЧЭМ

Турк улсын аялал

Ерөнхий мэдээлэл

Улс: Турк

Чиглэл:

Хугацаа: 7 шөнө, 6 өдөр

Эхлэх өдөр: 2021-07-23 - 2021-07-30

Код: ш62020

Үзэх зүйлс

Apollon Temple, The ancient city of side, Manavgat Waterwall зэрэг үзвэрүүд

Үзэсгэлэнт **Дюдэн хүрхрээ**, Турк улсын **үнэт эдлэлийн дэлгүүр, савхи нэхий эдлэлийн дэлгүүр болон үндэсний барааны дэлгүүрээр зочлох, Олимпус хэмээх кабель машинд** суун Анталия хотыг дээрээс нь харах, Дараа нь **Амьтны хүрээлэн** руу явах, **Даруулт завиар** газар дундын тэнгисийн гайхалтай байгалиар аялах, **Анталия хотын худалдааны төвөөр зочлох,**

Үнэ

Сонголт 1 - Нийт үнэ: **4,190,000₮**

Аяллын хөтөлбөр

Өдөр 1. УБ-Анталия

Энэ өдөр тогтсон цагт Чингис хаан нисэх онгоцны буудал дээр цуглаж, өглөөний 07:00 минутанд УБ хотоос ниснэ. Замдаа Туркийн хотод түр зогсон онгоцоо сумлана. Онгоц сумлах үед зорчигч бууж, сууж болохгүй анхаарна уу. Дараа нь үргэлжлүүлэн Анталия хот руу ниснэ. Ингээд ойролцоогоор 8-9 цаг ниссэний дараа Туркийн цагаар өглөөний 11:00 цагт Анталия хотод газардана. Энэ үед орон нутгийн хөтөч болон Монгол хэлтэй хөтөч, тайлбарлагч таныг угтан авч зочид буудалд хүргэж үйлчилнэ. Таны байрлаж буй зочид буудал нь 5 одтой зочид буудал байх бөгөөд өглөө, өдөр, оройн хоолыг буффетээр үйлчлэх юм. Мөн уух зүйлс бүгд аяллын зардалд багтсан тул та өөрийн сонголтоор зочид буудлаас хоол ундааны зүйлсээ зооглох юм. Ингээд зочид буудалд хүргүүлэн өрөөндөө байрлана. Тогтсон цагт цуглан энэ өдрийн аялалдаа гарна. Энэ өдөр та Apollon Temple, The ancient city of side, Manavgat Waterwall зэрэг үзвэрүүдийг үзнэ. Орой нь зочид буудалдаа ирэн оройн хоолондоо ороод амарна.

Өдөр 2. Анталия

Энэ өдөр чөлөөт өдөр. Та өөрийн хүслээр хотоор зугаалж, гадуур худалдан авалт хийх боломжтой. Өглөө, өдөр, оройн хоолоо зочид буудалдаа иднэ. Орой нь буудлын өрөөндөө байрлан амарна. /чөлөөт өдөр тул хөтөч, унаагаар үйлчлэхгүй/

Өдөр 3. Анталия

Өглөөний цайгаа зочид буудалдаа зооглоно. Дараа нь чөлөөт цаг. Ингээд өдрийн хоолны дараа Үзэсгэлэнт **Дюдэн хүрхрээг үзэж**, дурсгалын зураг татуулна. Дараа нь Турк улсын **үнэт эдлэлийн дэлгүүр, савхи нэхий эдлэлийн дэлгүүр болон үндэсний барааны дэлгүүрээр** зочилно. Хүсвэл та худалдан авалт хийх боломжтой. Эндээс та зөвхөн Турк улсад байдаг Султанит чулууг шигтгэн урласан алт мөнгөн эдлэл, Европ руу өндөр үнээр нийлүүлдэг үслэг эдлэлийг хямд үнээр худалдан авах боломжтой. Орой нь зочид буудалдаа хүргүүлэн байрлан амарна.

Өдөр 4. Анталия

Өглөөний цайгаа зочид буудалдаа иднэ. Дараа нь чөлөөт цаг. Өдрийн хоолны дараа тогтсон цагт цуглан энэ өдрийн аялалдаа гарна. Эхлээд **Олимпус хэмээх кабель машинд** суун Анталия хотыг дээрээс нь харна. Дараа нь **Амьтны хүрээлэн** руу явна. Үргэлжлүүлэн **Даруулт завиар** газар дундын тэнгисийн гайхалтай байгалиар аялна. Орой нь буудлын өрөөндөө байрлан амарна.

Өдөр 5. Анталия

Энэ өдөр чөлөөт өдөр. Та өөрийн хүслээр хотоор зугаалж, гадуур худалдан авалт хийх боломжтой. Өглөө, өдөр, оройн хоолоо зочид буудалдаа иднэ. Орой нь буудлын өрөөндөө байрлан амарна. /чөлөөт өдөр тул хөтөч, унаагаар үйлчлэхгүй/

Өдөр 6. Анталия

Өглөөний цайгаа зочид буудалдаа зооглоно. Дараа нь чөлөөт цаг. Өдрийн хоолны дараа тогтсон цагт цуглан **Анталия хотын худалдааны төв** руу явна. Худалдааны төв дээр ирээд чөлөөт цаг. Та өөрийн хүслээр худалдааны төвөөр зугаалж, худалдан авалт хийх боломжтой. Орой тогтсон цагт унаагаар зочид буудалдаа хүргүүлнэ. Оройн хоолоо зочид буудалдаа зооглоод амарна.

Өдөр 7. Анталия

Өглөөний цайгаа зочид буудалдаа уусны дараа буудлын өрөөгөө хүлээлгэж өгөн, унаагаар нисэх онгоцны буудал хүргүүлэн Улаанбаатар хотын зүг **13:00** цагт ниснэ. Замдаа мөн сумлах тул түр зогсолт хийнэ. Сумлах үед онгоцноос бууж, суух боломжгүйг анхаарна уу. Ингээд **6 сарын 25-26нд** шилжих шөнийн **03:00** цагийн орчим Улаанбаатар хотод газардана. Ийнхүү аялал өндөрлөнө.

Аялалын зардалд багтсан

- УБ – Бишкек/Алмата – Анталия – Бишкек/Алмата – УБ ирж очих нислэгийн тийз

- 5 одтой зочид буудлын энгийн өрөөнд 2-оор байрлах зардал
- Угтаж, үдэх үйлчилгээ
- Хөтөлбөрт заасан тооны хоол
- Хөтөлбөрт заасан үзвэр, үйлчилгээний тасалбар
- Аяллын унаа
- Анталия-д Монгол хэлтэй Аяллын хөтөчийн үйлчилгээ
- Гадаадад зорчигчдын гэнэтийн ослын даатгал

Аялалын зардалд багтаагүй

- “Аяллын зардалд багтсан”-с бусад зардал
- Хувь хүний хэрэглээний зардал
- Хөтөлбөрт ороогүй хоол, уух юм, унаа, үзвэр үйлчилгээний зардал
- Чөлөөт өдрийн хөтөч авбал хөтөчийн хөлс, өдөр оройн хоол, унаа, үзвэр
- Хөтөч, жолоочийн гарын мөнгө